

МОНГОЛ ХЭЛНИЙ “ODU-Ā” ХЭМЭЭХ ЦАГИЙН НЭРИЙН УТГА, ХЭРЭГЛЭЭ

Ч.Бямбаханд

Монгол хэл шинжлэлд орон цагийн нэрийг ерөнхийлөн авч үзэхээс гадна тусгайлаг харьцангуй талаас нь орны нэр, цагийн нэр хэмээн нарийвчлан авч судлах боломжтой юм. Бид энэхүү судалгаандаа орон цагийн нэрийн салшгүй чухал хэсэг болох цагийн нэрээс *odu-ā* хэмээх үгийн утга, хэрэглээний онцлогийг гаргахыг зорьсон болно.

Монгол хэлний *odu-ā* хэмээх цагийн нэрийг эртний грек хэлээр ἄρτι, ἀρτίως, νῦν, ἤδη, латин: nunc, дани: nu, фин: испани: ahora, уа, итали: adesso, ora, nyt, англи: now, right now, германл: jetzt, франц: maintenant, aujourd'hui, шинэ грек хэл: τώρα, хятад: 現在 (xiànzài), япон: 今 (いま, ima), 目下 (もっか, mokka); 2) 今日 (きょう, kyō), солонгос: 지금, орос: сейчас, теперь, ныне, швед: nu, түрк: şimdi гэсэн хэлбэрээр тус тус тэмдэглэдэг.


Үүнээс үзвэл, монгол хэлний *odu-ā* хэмээх үг төрөл ба төрөл бус хэлэнд бүтээврийн түвшинд ижил төстэй шинж ажиглагдахгүй боловч үүргийн хувьд төстэй байх нь дамжиггүй юм. Учир юун хэмээвээс хүмүүс бид юм, үзэгдлийг нэгэн янзаар сэтгэвч өөр өөр янзаар илэрхийлдэг нь хэл сэтгэхүйн салшгүй холбоо харилцааны илрэл гэлтэй.

Я.Шмидт цаг ба цагийн үргэлжлэх утгатай дайвар үгэнд *say-a*, *ene-edür*, (1931:86), О.Ковалевский цаг заасан дайвар үгэнд *ene edr*, *mönüdür*, *edügē*, (1835:122), Александр Бобровников цаг хугацаа заасан дайвар үгэнд *edüge*, *odu* (1835:77-82), А.Попов, О.Ковалевский нар цаг заах дайвар үгэнд *odu-γ-ā*, *darui* (1847:177), А.Д.Руднєев үүсмэл дайвар үгэнд *odu-γ-ā*, *edügē* (1905:85-93), В.И.Рассадин монгол хэлний дайвар үг *odu-ā* нь буриад хэлнээ мэнээ (одоо), дайвар үг нь *-na³*, *-ra⁴*, *-ši*, *-yār²* дагавраар үүсч, *-bār⁴*, *-da⁴*, *-ā⁴*, *-γ-ā⁴* (харьяалахын тийн ялгал) нөхцөлөөр хэлбэрждэг гэжээ. Харин Г.Д.Санжеев *mödü* (←*mön-dür*?) халх. мөдсейчас же, теперь же, *önüdür* (←*ene edür*) халх. өнөөдөр, бур. үнөөдөр сегодня. ср. бао. нудэ-. *önü-e* (←*önüdür*: апокона) халх. өнөө сейчас, теперь; сегодня (2016:225) гэж үзсэн бол харин Б.Х.Тодаева бүтээвэр зүйн шинжээр нь ялгаад, язгуур дайвар үгт үл хувилах идэвхгүй язгуураас үүсдэг “... *oroī*, *ürgelji*, *qa-ya*, *erte*, *odu-ā*” зэрэг орчин цагийн монгол хэлэнд дагавартай хэрэглэгддэг үгсийг багтааж, улмаар үүсмэл дайвар үгт нэр үг, тэмдэг нэр, төлөөний үг, үйл үг болон бусад үгсийн аймгаас дагавраар үүсдэг үгсийг авч үзээд, мөн цагийн утгат дайвар үгэнд *odu-ā*, *oroī*, *üdeši*, *erte*, *urida*, *qoyiši*, *daraγ-ā*, *ürgelji*, *darui* хэмээн *odu-ā* гэх үгийн онцлогийг тодруулжээ.

Ш.Лувсанвандан гүйцэд ялгаллагдах нэр үгэнд нэр үг, тэмдэг үг, төлөөний үг, тооны үгсийг багтааж, хагас ялгаллагдах үгэнд *odu-ā*, *qojim*, ...*marγāši*, *erte*, *oroī* (1939:75) гэх мэт үгийг, хожим тэрээр дутмаг нэрэнд орон цаг, зүг чиг заасан бүлэг үгэнд *erte*, *oroī*, *odu-ā*, *marγāši*, *qojim* (1951:115), А.Лувсандэндэв, нэр үгийн айгаас дайвар үгийн айд шилжиж буй үгэнд ... *erte*, *darui*, *oroī*, *urida*, *darui* (1956, 2002:73), Ц.Жанчивдорж, Б.Рагчаа нар үүсмэл дайвар үгэнд мөхсөн язгууртай тийн ялгалаар хагас ялгалагдах үүсмэл дайвар үгэнд ... *erte*, *oroī*, *qojim*, *urida*, *imaγta*, *odu-ā*, зэрэг үгийг утгаар нь цагийн дайвар үгэнд *erte*, *oroī*, *daraa*, *qojim*, *urida*, *odu-ā*, *imaγta*, *üdeši*, *önüdür* (1962:30-33), П.Бямбасан *odu-ā* гэх үгийг үүсмэл нэр үгийн хувиллаар заримдаг хувилдаг үг (1968:51-55), *qojim*, *imaγta*, *üter*... *odu-ā* (Орчин цагийн монгол хэл 1997:243) гэх мэт үгсийг зөвхөн цаг заасан утгатай гэсэн бол Д.Цэрэнпил,

Р.Куллман нар *önüdür, maryāsi, öcügедүр, urjидur, nögügедүр, одu-ā, daray-ā, qojim, ayār, müd, uridu, sayiqan, erte, erteken, oroi, oruyiqan, egüride, önide, aşida, egenegte, nasuda, ürgülji, imayta, dangdā, kejiyēde, qōyisida, ütdür, tedüken, darui, dour-a, tür, genetde, qāya, jarimdayān, bayingyu, tuji* (2008:221-229) зэрэг үгсийг хамруулан үзжээ. Харин Ц.Өнөрбаян утга зүйн шинжээр нь цагийн нэрэнд өнгөрсөн (урьд, эрт, өчигдөр, уржигдар, ноднин, сая, хэдүйн); одоо (одоо, өнөө, өнөөдөр, эдүгээ); ирээдүй (хожим, дараа, орой, маргааш, даруй, мөдхөн) (2004:221), *odu-ā*, өдгөө, эдүгээ гэх үгийг ерөнхий цаг хэмээгээд сая, үүрд, одоо гэх үгийг цагийн утга илтгэнэ (М.Базаррагчаа 2005:188) гэжээ.

Цаг хугацааны концептын хүрээнд *odu-ā* хэмээх цагийн нэр нь өнгөрсөн хийгээд одоо цагийн өмнөх үе, одоо үе, ирээдүй хийгээд одоогийн дараа үеийн тасралтгүй эргэлтэнд оршин буй тогтолцоот цикл төдийгүй өмнөх үеийн төгсгөл, ирээдүй үеийн эхлэл буюу төгсгөлгүй эхлэл, эхлэлгүй төгсгөл байдаггүйн илэрхийлэл төдийгүй өнгөрсөн ирээдүй цагийн огтлолцол дээр үүсдэг байна. Өөрөөр хэлбэл, одоо цагийн утга нь өнгөрсөн цагийн төгсгөл, ирээдүй цагийн эхлэл болно. Үүнийг хэрхэн илэрч буйг дараах загвараас ажиглаж болно.



Монгол хэлний *odu-ā* хэмээх цагийн нэрийн утга өдөр тутмын ярианд дангаараа болон нийлмэл үгийн хүрээнд түгээмэл хэрэглэгддэг. *odu-ā* гэх үг нь өгүүлэхүүнд захирагдаж цагийг илэрхийлэхийн зэрэгцээ үйл үгийн хэл зүйн цагтай учир зүй логикийн ойлголтоор хослон илэрдэг байна. Тухайлбал үгийн сангийн түвшинд;

1. *odu-ā* (Ntime.) *edügē* (өдгөө), өнөө, өнөөдөр→*ene edür*)

1.1. дан үгээр:

odu-ā (үйл хөдлөл болж буй агшин~ хором~мөч)

Энэ үг нь монгол хэлний бичгийн хэлэнд *edügē* гэх хэлбэрээр тохиолддог. Г.Рамстедт “Халимаг хэлний толь”-доо *odā* (одоо), *odā-tšigñ* (одоо цагийн), *odā kürtl* (одоо хүртэл), *odāyās* хогān эсвэл *odāyās awn* (одоогоос аван), [*odu-ā, edügē*] (1935:283), *odāk* (одоо), эгнээний төгсгөл, *odāk* tsag (одоо цар) [*odua ki*] (1935:283), *ödge* (бичгийн хэл) одоо, (=odā), *ödge tsag* (өдгөө цар), [*edüge*→*e-, *en-(энэ)], *ödū*-хараахан болоогүй, арай болоогүй [*e, düi*] (1935:293), үүнийг “Монголын нууц товчоо”-ны жишээгээр Эрих Хэниш *edo'e* (одоо) *edo'e iregu cah bolba, jetzt ist die Zeit, da er kommt 3I, edo'et* (tur) одоо (*jetzt*) 248,5 (1939:47) гэж тэмдэглэсэн байна.

odu-ā (Ntime.) гэх үг нь *daru-i* (participle→Ntime.) удалгүй тэр дороо, тун удахгүй, даруй, даруй түргэн-сааталгүй түргэн, шуурхай, нэн хурдан, тэр дороо, дав даруй, үтэр түргэн, тэр дороо гэх үгтэй найруулгын явцад ойролцоо утгатай болох хийгээд заримдаа солин найруулж ч болдог байна.

odu-ā çi

-Одоо ч бид удахгүй хөдөө гарч, хэдэн малаа хариулан амар суух юм бодож байна. Юу болох юм бэ мэдэхгүй, баатар аа! (Д.Нацагдорж, “Монгол ардын суут” жүжиг)

-Одоо ч дүүрээ шив.; -Одоо ч тусгүй шив. (Д.Нацагдорж, “Монгол ардын суут” жүжиг)

odu-ā l

-Одоо л ухаан сууж дээ.

-Одоо л хүн чанараа харуулж байна даа.

odu-ā, oduyā-qan (даруйхан, удахгүй)

Монгол хэлэнд ихэвчлэн тохиолддог монгол хэлний -qan, манж хэлний -kan дагавар нь багасгасан утга илэрхийлдэг. Энэ нь монгол хэлэнд *nigeken, tereken, edüiken, kedüi-*

kedüiken, end-endeken гэх үгтэй төстэй байна. Тухайлбал kalm: odā→odāʻan, kh: odō→odōʻon, (G.J.Ramsdelt 1952:210) гэх мэт.

-Алив надад одоохон заагаад өг. (www.montsame.mn)

-Харин сүүлийн үед тэд банкийг одоохон төрд авъя гэж зүтгэгсэд боллоо. (www.dailynews.mn)

-“Ах нь чамаас ганц нэг юм” асуугаадахья гэхэд “За, одоохон ах аа” гээд мөн л таг болов. (www.dailynews.mn)

-Ээж нь одоохон ирнэ гэсэн гээд хүлээж байсан. (www.dailynews.mn)

-Спорт нөхөрлөлийн дарга Борбаатар “Би одоохон” гээд гараад гүйжээ. (www.dailynews.mn)

одоочлох- орчин үежүүлэх

одоочлох (Ntime.→V) ~ эдүгээчлэх (Ntime.→V),

эдүгээчлэл (Ntime.→N) – өдгөөчлөл (Ntime.→N)

1.2. Нийлмэл үгийн хүрээнд:

одоо даруй-тун удахгүй (ярианы хэл)

одоо одоо-богино хугацаанд (давтах арга)

эрт өдгөө-өнгөрөн одсон болон одоогийн цаг үе (бүр одоо, мөн одоо)

одоо цаг ~ эдүгээ цаг ~ энэ цаг ~ өдгөө цаг ~ орчин цаг (өнгөрөн одсон болон одоогийн цаг үе) үүнийг найруулга зүйн талаас одоо үе ~ эдүгээ үе ~ энэ мөч ~ энэ үе ~ өдгөө үе ~ орчин үе гэх мэтээр солин найруулж болно.

1.3. Шууд бус утга:

одоо шиг-эдүгээ шиг (адилтгах)

Тэр үед залуучууд одоо шиг машин унадаггүй байсан шүү дээ.

одоо шиг л-эдүгээ шиг л

Одоо шиг л эерэг бодлуудаа тээж яваарай.

одоо дээр (маш яарах, нүдний өмнө)

одоочлох ~ эдүгээчлэх ~ өдгөөчлөх-шинэчлэх, орчин үежүүлэх

одоо байтлаа-тухайн үед аливаа зүйл болохоо болих

-Одоо байтлаа чи чинь хичээлээ хийхгүй хаагуур яваад байна аа?

-Одоо л эс бол хэзээ ч үгүй (эсрэг утга)

-Одоо л эс бол хэзээ ч үгүй л гэж бодоорой доо.

Харин өгүүлбэр зүйн үндсэн асуудал, үндсэн нэгжүүдийн хэлний давхарласан тогтолцоог гаргахад үг холбох ёс, үг холбох арга, хэрэглүүр чухал ач холбогдолтой. Тэгвэл монгол хэлний орон цагийн харьцааны нэрээс цагийн нэрийн өгүүлбэрт эзлэх байр, үүрэг, онцлогийг нарийвчлан судлах нь өгүүлбэр зүйн нэгж, тэдгээрийн хоорондын холбоо, дараалал, хэл зүйн харилцан хамаарлыг тодруулахад хэрэгтэй юм.

Үйлийн болох цаг түүний эхлэх, төгсөх цаг үеийг зааж өгүүлэхүүн гишүүнд холбогдоно. Цагийн нэр odu-ā, дагавар үгт нэр үг, өгөх орших, гарах, үйлдэхийн тийн ялгал болон үндсээр хэлбэржихээс гадна бэлтгэх, угтах, үргэлжлэх хэлбэрээр тохиолдоно. (Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүй, 1989:153)

2.1 odu-ā гэх цагийн нэр нь бие дааж байц гишүүний үүрэг гүйцэтгэнэ. Үүнийг найруулга зүйн талаас darui, mōd, edüge гэх хэлбэрээр ч солин найруулж болно.



Орон цагийн байц голдуу өгүүлэгдэхүүний өмнө байх боловч, хэрэв түүн дээр утгын өргөлт ноогдвол өгүүлэгдэхүүний дараа орно. (Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүй, 1989: 173)

Монгол хэлний цагийн нэрийн байц гишүүн болох, монгол хэлний төгс өгүүлэхүүн нь цаг болон биеэр төгсгөх нөхцөлөөр хувилах талаар олон эрдэмтэд судалсан байдаг. Гэвч үйлийн болох цаг, түүний эхлэх, төгсөх цаг үеийг зааж өгүүлэхүүн гишүүнд холбогддог талаар тодруулан авч үзье.



-Цагийн нэр *odu-ā* нь энгийн өгүүлбэрт цагийн байц гишүүний үүргээр ороход өгүүлэхүүн гишүүн нь цагаар төгсгөх нөхцөлөөр хэлбэржинэ.

-Цагийн нэр *odu-ā* нь энгийн өгүүлбэрт цагийн байц гишүүний үүргээр ороход өгүүлэхүүн гишүүн нь биеэр төгсгөх нөхцөлөөр хэлбэржинэ.



Жишээ-1



Жишээ-2



Жишээ-3



Үүнээс ажиглавал, *odu-ā* гэх үг нь бие даасан байц гишүүний үүргээр орно. яв-, оч- үйл язгуур нь хоёулаа нэг орон зайгаас нөгөө орон зайд шилжих хөдөлгөөнийг заана. Гэвч яв- язгуур нь нэг орон зайгаас “гарах салах” утга зааж байгаа бол харин оч- үйл язгуур нь нэг орон зай руу чиглэх орон зайн утгыг голлон зааж байна.

-Харин дээрх жишээнээс ажиглахад тухайн өгүүлбэрт *odu-ā* гэх цагийн нэр орсон тохиолдолд монгол хэлний цагаар төгсгөх *-na⁴*, *-b*, *-jē²*, *-lā⁴* нөхцөлөөс зөвхөн *-na⁴*, *-lā⁴* нөхцөлөөр өгүүлбэрийн төгс өгүүлэхүүн нь хэлбэржиж байна.

-Тус өгүүлбэрийн төгс өгүүлэхүүн нь *-na⁴* нөхцөлөөр хэлбэржиж одоо, ирээдүй цагийн утга заах бол *odu-ā* гэх цагийн нэр орж мэдэгдэж өнгөрсөн цагийн *-lā⁴* нөхцөлөөр хувилж ирээдүй цагийн утга илтгэж байна. Харин *-b*, *-jē²* нөхцөлөөр хувиргаж болохгүй байгаа нь сонирхолтой юм.

-Харин энэ өгүүлбэрийг ярианы хэлэнд “Би одоо явлаа гэж тэр хэлсэн.” гэхэд “ge-”-т өгүүлбэрт гол өгүүлбэрийн өгүүлэхүүн нь өнгөрсөн цаг илтгэж, гишүүн өгүүлбэрийн төгсгөх нөхцөлөөр хэлбэржсэн өгүүлэхүүн нь ирээдүй цаг зааж байгаа нь түүнд захирагдаж байгаа *odu-ā* гэх цагийн нэртэй хамаатай байна.

Энэ нь өгүүлбэрийн утга санааг илэрхийлэхэд гишүүд төдийгүй гишүүдийн байр, хэлбэржилт харилцан чухал холбоотойг харуулж байна.

Англи хэлний үндэсний корпус (BNC)-т “одоо” (*now*) гэх үг ярианы хэлэнд нь 82, бичгийн хэлэнд 63, дайвар үгэнд 5 дугаарт эрэмбэлэгдсэн (www.natcorp.ox.ac.uk) зэргээс харахад цаашид монгол хэлний яриа ба бичгийн корпус *odu-ā* гэх цагийн нэрийн хэрэглээ монгол хэлэнд ч чухал үүрэгтэй төдийгүй давтамжийг нарийсган судлах боломж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл одоо гэх үг нь үгийн сангийн түвшинд өргөн хүрээг хамрахгүй ч хэл зүйн хэрэглээнд түгээмэл ашиглагддаг байна. Тийм учраас монгол хэлний *odu-ā* гэх үгийн утга, давтамж, хэрэглээг өгүүлбэрийн онцлогоос тодруулан гаргах нь чухал юм.

Германы Лайпцигийн Их Сургуулиас гаргасан 2011 оны Монгол хэлний корпус 377,892 өгүүлбэр байгаагаас *odu-ā* гэх үг 4,176 тохиолдолд хамрагдаж байгаа бөгөөд 134 дүгээрт эрэмбэлэгдэж, давтамж нь 5 дугаар түвшинд багтаж байна. (corpora.uni-leipzig.de) Энэхүү корпус *odu-ā* гэх үг (0.34), харин түүнтэй хамаат үгэнд дараах үгсийг давтамжаар нь тодруулан гаргасан байна. Эндээс харахад давтамжаараа *odu-ā* гэх үгтэй хамгийн их тохиолдож байгаа үг нь яг (0.23), *bi* (0.23), *ene-edür* (0.23), *ċini* (0.21), *bide* (0.21) буюу уяу *odu-ā*, *bi odu-ā*, *bide odu-ā* гэх мэтээр аман ба бичгийн хэлэнд ашиглагдаж байгаа төдийгүй өгүүлбэрийн утгаас шалтгаалан *odu-ā* гэх үгийн байранд *ene-edür* гэх үг тохиолдох ч боломжтой нь ажиглагдаж байна.

-Цагийн нэр *odu-ā* нь (*Ntime.inst.←V*) хэлбэржиж байц гишүүний үүргээр тохиолдоно.

-Элсэгчдийн хэчнээн нь их, дээд сургуульд элсэх боломж байгаа эсэх талаарх мэдээллийг Боловсролын үнэлгээний төвд одоогоор (одоо хүртэл) ирүүлээгүй. (www.dailynews.mn)

-Байгалийн гамшигт нэрвэгдэгсэд болон гарз хохирлын тухай мэдээлэл одоогоор (*Ntime.inst.←V*) тодорхойгүй байгаа юм байна.

-Гэхдээ одоогоор чуулган (*Ntime.inst.←V*) хараахан эхлэх болоогүй байна.

“*odu-ā*, уяу *odu-ā*” гэх үг нь утгын талаас хол зөрөхгүй боловч өгүүлбэрийн хэрэглээний явцад утгын ялгаа нь тодордог. Тухайлбал, “уяу *odu-ā*” гэдэг нь өөр цаг хором байхгүй гэсэн баймж утгаар тохиолдоно.

-Тэр жилийнхээ шилдэг зүүн хамгаалагч цолыг хүртсэн намайг шоглосонд уур хилэн дээд цэгтээ тултал хүрч яг одоо энэ багаас яваад өгье гэсэн бодол толгойд эргэлдсэн. (www.dailynews.mn)

-Тэгтэл нөгөө хоёр хүү "Баярлалаа, та энэ батламжийг аваад яг одоо ХААН банк руу оч.

-Яг одоогийн энэ (яг) хамтарсан шиг үүрд нэгэн дээвэр дор орно гэж тохиролцсон байв даа. (www.dailynews.mn)

2.2. *odu-ā* гэх цагийн нэр нь нэр үгийн өмнө тохиолдвол тодотголын үүрэгтэй тохиолдоно. 2011 онд гарсан Германы Лайпцигийн их сургуулийн Монгол хэлний корпус (corpora.uni-leipzig.de) *odu-ā* гэх үг нь ямар үгсийн өмнө хамгийн их тохиолдож байгаа давтамж гарсан байна. Жишээ нь: Надад одоо дахиад цэргийн алба хаах насны хоёр хүү байна. (corpora.uni-leipzig.de) Үүнд (*Ntime.gen.+bayidal*) гэх хэлбэр нэлээдгүй тохиолдож байна. Тухайлбал,

-Тус аймагт хүйтэрч цасаар шуурч одоогийн байдлаар 28 мянга гаруй мал хорогдоод байгааг аймгийн Засаг дарга нь ярьж байна.

-Харин одоогийн байдлаар (*Ntime.gen.+bayidal*) аль компани, ямар шалгуураар дараагийн шатанд үлдсэн тухай албан ёсны мэдээ алга.

-Гэвч ийм төрлийн техник бүтээх оролдлого одоогийн байдлаар (*Ntime.gen.+bayidal*) Орост тийм ч үр дүнд хүрээгүй байгаа аж.

-Хүүхэд орчноосоо хамааралтай байдаг болохоор тэр үеийн хүүхдүүд, одоогийн хүүхдүүдийн хооронд (*Ntime.gen.+bayidal*) их ялгаа байдаг.

-Энэ бол (*Ntime.gen.+bayidal*) одоогийн ханшаар 150 шахам тэрбум төгрөг. (www.dailynews.mn)

2.3. *odu-ā* гэх цагийн нэрийн ард туслах үг тохиолдвол арын үг нь үүргээ алдаж туслах үгийн үүрэгтэй болно.

-Энэ хаалга одоо хүртэл онгорхой байна.

-Хоёр ихрийг одоо болтол хүмүүс хооронд нь ялгадаггүй гэнэ.

-Сайд одоо болтол ойлгоогүйг гайхаж байна.

2.4. Орон цагийн харьцааны нэр холбоосын үүргээр тохиолдоно. odu-ā ~darui

-Даруй өглөө харьсан боловч үдэш санагдан эргэж ирсээр, нэгэнт хэд хэдэн сар болж, баруун дамнуурчны ба Гандангийн хоёрын хооронд нэг нарийхан шинэ зам нэгдэв. (Д.Н)

-Өчигдөр орой ахмадынхаас Даян гуай ирж, одоо зургаа хоноод 15-нд авлахаар хэлэлцэж явав. (Д.Нацагдорж, Адуу манаад)

-Гэтэл үүд нээгдэж, доктор гарч ирээд, одоо зүгээр сайн болно хэмээн хэдхэн үг хэлээд, сувилагчид орос хэлээр хэдэн үг хэлж дуусахад, хоёр охин зэргээр лавлавал, одоо гурав хоноод эдгэнэ гэв. (Д.Нацагдорж, Далдыг үзэгч)

Үүнээс дүгнэж үзвэл, одоо гэх цагийн нэрийн утгыг хэрэглээний хүрээнд нь дараах байдлаар дүгнэн үзэж болно. Тухайлбал,

1. odu-ā (Ntime.) түр зуурын, тухайн агшин

Одоо үүнийг хэлэхэд тохиромжтой цаг боллоо.

Яг одоо хүртэл санаа сэтгэл хувираагүй байна.

2. odu-ā (Ntime.) өнгөрсөн үеэс одоод, өнгөрсөн үйл явдлыг цувуулан хэлэх өгүүлэмж

Монгол улс одоо саарал жагсалтанд орохоор болсон.

3. odu-ā, өнөө үед, одоо, өнөөдөр (Ntime.) эдгээр цаг үед

Одоо ч хотын гудамжинд машин унаагүй хүн ховор болж дээ. Өнөөдөр хүүхэд бүр гар утас, зурагт, компьютерыг чөлөөтэй хэрэглэдэг болсон.

4. odu-ā (Ntime.) захирах, зэмлэх тушаал эсвэл зэмлэл, хүсэлтийг урьдчилж хэлэх үе

Одоо бич. Одоо золго. Одоо боль. Одоо анхаар. Одоо золгоорой. Одоо бичээрэй.

5. odu-ā (Ntime.) өдгөө, өдий-одоогийн байдлаар

Өдий наслахад юу эс үзэх вэ дээ. Одоо ч техникийн зуун болж дээ.

6. odu-ā гэх үгийг даруй, тэр дороо, шууд, нэн даруй, ойрын үед (Ntime.) гэх үгээр солин найруулж цаг алдалгүй, эргэлзээгүйгээр хийж буй үйлийн утгыг тодруулна. Тэр даруй бичив. Тэр дороо инээв. Тэр шууд л хэллээ. Нэн даруй шийдэх асуудал гарлаа. Би одоо очлоо.

7. odu-ā (Ntime.) нь ярианы хэлэнд өгүүлэгч этгээд ярих явцдаа зогсолт авах, санаагаа бодох, хоёр санааг холбох, нэг санаанаас нөгөө санааг илэрхийлэхэд шилжих, сул үгийн үүргээр ч орох тохиолдол цөөнгүй байна. (Тансаг аа, одоо ингэхэд гэр чинь аль зүгт байна аа.) гэх мэт.

8. odu-ā гэх үг нь ярианы хэлэнд нэг санааг дараагийн санаатай холбох хэрэгсэл болно. -“Одоо дараагийн амьдралаа бодоорой”, “Одоо дараагийн асуудалдаа орцгооё” гэх мэт.

Монгол хэлний орон цагийн харьцааны нэр нь үйл үгсийн өмнө гарахын тийн ялгал, нэрийн өмнө харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр захирагдаж, орон цагийн утгат тийн ялгалын саармагшсан тэг хувилбарыг далд агуулах болсон нь завсрын шинжийг илтгэсэн “царцмал” ай болж орон цагийн утгыг өгүүлбэрийн үйл явдалд нэлэнхүйд хамааруулах үүднээс заримдаг буюу дутмаг хувилах онцлогтой.

Монгол хэлний дайвар үг буюу орон цаг харьцааны нэрийн дотор тодорхой байр эзлэх цагийн харьцааны нэр “одоо” монгол хэлэнд давтамж ихтэй орон цагийн нэр төдийгүй бичгийн хэлэнд тогтмол хэрэглэгддэг ч, олон дахин хэрэглэвэл үг давтсан, эсвэл найруулгын зэргийн өнгө аясыг бууруулах алдаа үүсгэх талтай, харин ярианы хэлэнд цагийн утгыг тодорхой болгоод зогсохгүй тухайн яригч бичигч этгээдийн сэтгэлийн өнгө аяс, тухайн нөхцөл байдалд хэрхэн хандаж буй хандлагыг ч илэрхийлэх боломжтой юм.

Resume

Clarifying the study on place-time relative nouns in Mongolian is significant for distinguishing the difference of meaning in other parts of speech. Place-time relative nouns in Mongolian have commonly been used by the surface and transformative structure but few theoretical and practical studies have been done. That's why we have chosen this subject. “odu-ā” is time relative nouns, which are included in an adverbial group, are not only complicated but also attention-grabbing subjects for the study of modern Mongolian.

Номзүй

- Базаррагчаа М.** 2005. *Монгол хэлний өгүүлбэр судлал*. Уб.,
- Бобровников А.** 1835. *Грамматика монгольского языка*. Санктпетербургъ. 1835. стр.77-82.
- Бямбасан П.** *Зарим дайвар үгийн тухай*. Хэл зохиол судлал. Т-V, f3. Уб.,1968. х. 51-55.
- Жанчивдорж Ц., Рагчаа, Б.** *Монгол хэлний зүй (сурах бичиг)*. Уб., 1962. х. 30-33.
- Ковалевский О.** *Краткая грамматика монгольского книжного языка*. Казань. 1835. стр.122.
- Лувсандэндэв А.** *Монгол хэлний үгсийг аймаглах тухай асуудалд*. Уб.,1956 Монгол үндэсний хэл бүрэлдэн тогтсон нь. Уб., 2002. х. 73.
- Лувсанвандан Ш.** *Монгол хэлний зүй (сурах бичиг)*. Уб., 1939. х. 75.
- Лувсанвандан Ш.** *Монгол хэлний зүй (сурах бичиг)*. Уб., 1951. х. 115.
- Орчин цагийн монгол хэл**. Уб., 1997. х. 243.
- Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүй**, Уб., 1989:153
- Өнөрбаян Ц.** *Орчин цагийн монгол хэлний үг зүй*. Уб., 2004. х. 221.
- Попов А.** *Грамматика калмыцкого языка*. Казань.1847. стр.177.
- Ramstedt G.J.** *Kalmückisches Wörterbuch, Lexica Societatis Fennou-Ugricae III*. Helsinki, 1935, pp.283-293.
- Рассадин В.И.** *Очерки по морфологии и словообразованию монгольских языков*. Элиста. 2011. стр.211.
- Руднеев А.Д.** *Лекции по грамматике монгольского письменного языка*. С-Петербург. 1905. стр: 85-93.
- Санжеев Г.Д., Орловская М.Н., Шевернина, З.В.** *Этимологический словарь монгольских языков*. ISBN 978-5-89282-664-8, Т II, Москва, 2016. стр.225.
- Тодаева Б.Х.** *Грамматика современного монгольского языка*. Москва, 1951. стр.154.
- Tserenpil D., Kullmann R.** *Mongolian Grammar*. UB., 2008. p.221-229.
- Haenish E.** *Wörterbuch zu Monghol un Niuca Tobca'an (Yan-Ch'ao Pi-Shi)*. Geheime Geschihte der Mongolen, Leipzig, Otto Harrassowitz, 1939. Seite 47.
- Ramstedt G.J.** *Einführung in die Altaische Sprachwissenschaft*, I, II, III. Helsinki, 1957 S.75,185.
- Schmidt I.J.** *Grammatik der Mongolischen Sprache*. St.Petersburg. 1931. S-86.
- Нацагдорж Д.** “Бүрэн түүвэр” Уб., 2016. Мөнхийн үсэг ХХК.